



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар A/149

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын
үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.7, 13.2.10 заалтууд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай” А/190, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Түр журам шинэчлэн батлах тухай” А/290 тоот тушаалууд, ШУТИС-ийн “Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”, Захирлын зөвлөлийн 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын бүх түвшний сургалтыг 2021 оны 8 дугаар сарын 30-наас цахимаар, бакалавр, магистрын шинээр элсэгчдийн хичээлийг 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамжийг нэгдүгээр, оюутан суралцагчдад өгөх зөвлөмжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, батлагдсан удирдамжийг мөрдөн ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), СБЗГ-ын дарга (Д.Гэрэлт-Од), алба, төвийн захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, салбар тэнхимийн эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

367040724



ШУТИС-ийн Захирлын 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 149 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх удирдамж

НЭГ. Бүртгэл, элсэлт, шилжилтийн үйл ажиллагаа

Бүртгэл, элсэлт, хичээл сонголт

- ШУТИС-ийн Ерөнхий боловсролын ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ШУТИС-Коосэн технологийн коллеж, бакалаврын хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл, гэрээ, хичээл сонголтыг цахимаар зохион байгуулна.
- Ахисан түвшний хөтөлбөрт элсэгчдийн бүртгэл, гадаад хэлний шалгалт цахимаар, мэргэжлийн ярилцлага хорио цээрийн журмыг баримтлан бүрэлдэхүүн сургууль бүр дээр явагдана.
- Гадаад, дотоодын их дээд сургуулиас шилжин ирж суралцах болон хөтөлбөр хооронд шилжин суралцах хөдөлгөөнийг журмын дагуу шийдвэрлэнэ.

ХОЁР. Танхимын болон танхимын бус хосолсон сургалтын үйл ажиллагаа

- Шууд бус цахим хичээлд LMS платформ, шууд цахим хичээлд Microsoft Office 365-Teams програм ашиглана.
- Профессор багш нар хичээлийн материалыг монгол хэлээр чанартай боловсруулж, (гадаад хэлний хичээлээс бусад) хичээлийн хуваарийн дагуу, намрын улирал дуустал LMS системд 7 хоног бүр байршуулна.
- Хичээл бүр удирдамжтай байна. Удирдамжид суралцагчдын сурах үйлийг дэмжсэн тухайн хичээлийн суралцахуйн үр дүн, түүнд хүрэх арга зам, багшийн заах-харилцах-үнэлэх үйл ажиллагааг тодорхой тусгаж, оюутан суралцагчдад хүргэж, ойлгуулна.
- Профессор багш нь залгамж холбоо бүхий хичээлийн агуулгыг бататган, хосолсон сургалтын явцад суралцагчдыг хичээлд бүрэн хамруулахад идэвхи санаачлагатай ажиллана.
- Бие даалтын даалгавар гүйцэтгэх хугацааг 14 хоногоос багагүй байхаар тогтооно.
- Танхимын болон танхимын бус хосолсон сургалтад салбар, тэнхимийн эрхлэгч нар хяналт тавьж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хуралд тайлагнана.
- Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал танхимын болон танхимын бус хосолсон сургалтын тайланг 14 хоног тутам СБЗГ-т ирүүлнэ.
- Өмнөх улиралд цуцлагдсан болон зайлшгүй хийх шаардлагатай дадлагыг салбар, тэнхимээс гаргасан санал, удирдамжийн дагуу хийлгэж болно.

ГУРАВ. Оюутны дотуур байрны бүртгэл

- Дотуур байранд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, халдвар хамгааллын дэглэм баримтлан ажиллана.
- Оюутны дотуур байранд суух хүсэлтийг цахимаар хүлээн авна.
- Дотуур байранд орохоор бүртгэл нь баталгаажсан оюутан, суралцагчийг танхимын сургалт эхлэхээс өмнө хүлээн авах бэлтгэл ажлыг хангана.



Оюутан суралцагчдад зөвлөмж

НЭГ. Бүртгэл, хичээл сонголт

- Шинэ элсэгчдийн бүртгэл, гэрээ, хичээл сонголтыг цахимаар хийнэ.
- Бүх түвшний /ШУТИС-ийн Ерөнхий боловсролын ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ШУТИС-Коосэн технологийн коллеж, бакалавр, магистрантур, докторантур/ хөтөлбөрт суралцагчдын бүртгэл, хичээл сонголтыг цахимаар зохион байгуулна.
- Ахисан түвшний хөтөлбөрт шинээр элсэгчдээс суралцах чиглэлийн дагуу мэргэжлийн ярилцлага болон гадаад хэлний мэдлэгээр шалгалт авна. Шалгалт авах өдөр, цаг болон шалгалттай холбоотой мэдээллийг бүртгэлийн хугацаанд цахим хуудсанд байршуулна.
- “Оюутны хөгжлийн зээл” болон “Буцалтгүй тусламж”-д хамрагдах суралцагчдын материалыг цахимаар 9 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл хүлээн авна.
- 2021-2022 оны хичээлийн жилд мөрдөх 1 кредитийн үнэлгээ болон сургалтын төлбөр төлөх дансны мэдээллийг цахим хуудаснаас авна.

ХОЁР.Сургалтын үйл ажиллагаа

- 2021-2022 оны хичээлийн жилийн сургалт 2021 оны 8 дугаар сарын 30-наас цахимаар, 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр явагдана.
- Суралцагчид хичээл бүрийн удирдамжтай сайтар танилцаж, хичээлийн хуваарийн дагуу танхимын болон танхимын бус сургалтад идэвхтэй оролцоно.
- Шууд бус цахимаар LMS платформд байршуулсан хичээлийг намрын улирлын туршид судлах боломжтой бөгөөд шууд цахим хичээлд Microsoft Office 365-Teams програмаар оролцоно.
- Цахим хичээлд хэрэглэх ном сурах бичиг болон бусад материалыг ашиглахад номын санчаас нэвтрэх код авч, must.lib4u.net электрон каталогийн хаягаар нэвтэрнэ.

ГУРАВ.Оюутны дотуур байрны үйл ажиллагаа

- Дотуур байртай холбоотой зарыг ШУТИС-ийн цахим хуудсаар мэдээлж, дотуур байранд суух хүсэлтийг цахимаар хүлээн авна.
- Дотуур байранд орох бүртгэл нь баталгаажсан оюутан, суралцагчийг танхимын сургалт эхлэхээс өмнө хүлээн авна.
- Дотуур байранд халдвар хамгааллын дэглэмийн талаар мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг баримтлана.